



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2024.11.08 № 5/4602
танай _____-ны № _____-т


┌ **ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН**
ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ └

“Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай” Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/435 дугаар тушаалыг хавсралтаар хүргүүлж байна.

Тушаалын хэрэгжилтийг хангаж, иргэдэд хүндрэл чирэгдэл үүсгэлгүй, чанартай тусламж, үйлчилгээг үзүүлж ажиллана уу.

Хавсралт 5 хуудас

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА  Р.ГАНТУЯА



145243808



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 8/135

Улаанбаатар хот

Томуу, томуу төст өвчний үеийн
эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Томуу, томуу төст өвчний үеийн ор зохицуулалтыг 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хүүхдийн хэвтүүлэн эмчлэх ор дэлгэх, шилжүүлэх түр зохицуулалтын Төрөлжсөн мэргэшлийн болон тусгай эмнэлгийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эмнэлгийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар, насанд хүрэгчдийн дотор, мэдрэлийн тасгийн зохицуулалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа Сүхбаатар, Баянзүрх дүүрэгт шинээр ашиглалтад орсон эмнэлгүүдийн барилга, хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, томуу, томуу төст өвчний үед амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг хэвийн явуулж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (П.Эрхэмбулган)-т үүрэг болгосугай.

3. Эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ, Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээг уртасгасан цагаар ажиллуулах, хүлээн авах, яаралтай тусламжийн тасагт ачаалал ихтэй амралтын өдөр болон оройн цагаар эмч нэмж ажиллуулах зохицуулалт хийх, дэгдэлтийн үед өдрийн эмчилгээ, гэрийн эргэлтийг идэвхижүүлэхийг эрүүл мэндийн байгууллагын дарга захирал нарт даалгасугай.

4. Иргэдэд Томуу, томуу төст өвчний талаар зөвлөгөө өгөх 119, 103 утсыг 14:00-22:00 цагийн хооронд тогтмол ажиллуулахыг Нийгмийн Эрүүл мэндийн үндэсний төв (С.Өнөрсайхан), Нийслэлийн Эрүүл мэндийн газар (П.Эрхэмбулган)-т, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа)-д, 119, 103-ын зөвлөгөө өгөх утас дээр хүүхэд судлалын үндсэн мэргэшлийн суралцагчдыг ажиллуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

14124198


5. Нийслэлийн эмнэлгийн хүүхдийн тасагт ажиллах хүүхдийн мэргэжлийн эмч, сувилагч, хүүхэд судлалын үндсэн мэргэшлийн суралцагч эмч, Сувилахуйн сургуулийн төгсөх дамжааны оюутнуудыг хүний нөөцөөр хангахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д даалгасугай.

6. 2024 оны 286 дугаар тушаалаар батлагдсан “Томуу, томуу төст өвчний эмнэлзүйн заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах, түр оршин суугаа болон харьяалал тодорхойгүй иргэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүндрэл, чирэгдэлгүй үзүүлэхийг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, Удирдлага, зохион байгуулалт, мэргэжлийн арга зүй, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдааг хангаж ажиллахыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Алтантуяа), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа), Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв (А.Эрдэнэтуяа)-д, Нийслэлийн хэмжээнд ор зохицуулалтын баг ажиллуулахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (П.Эрхэмбулган)-т тус тус даалгасугай.

7. Томуу, томуу төст өвчний үед үзүүлж байгаа эмнэлгийн тусламж, үйлчилгээний эрүүл мэндийн даатгалын санхүүжилтэд хязгаар тогтоолгүй гүйцэт олгохыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (М.Нармандах)-т, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай санхүүжилтэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Санхүү, эдийн засгийн бодлогын газар (Л.Лувсан)-т тус тус үүрэг болгосугай.


8. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа), Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газар (Л.Баттөр)-т тус тус даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 2/435 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ТӨВ ЭМНЭЛГҮҮДЭД ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙГ ХЭВТҮҮЛЭН
ЭМЧЛЭХ ҮЕИЙН ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ

| № | Эрүүл мэндийн байгууллага | Хүүхдийн орны тоо | Шилжүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх дүүрэг хороо |
|---|--|-------------------|---|
| 1 | Халдварт өвчин судлалын үндэсний төв | 220 | Баянзүрх дүүргийн 8-11, 13-15, 19-20, 25-26, 34-36, 42, 43 дугаар хороо, |
| 2 | Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв | 400 | Хан Уул дүүргийн 9-25 дугаар хороо, Баянгол дүүргийн (Алтай хотхон) 24, 26-р хороо СХД-ийн Өнөр бүсийн 12-17 дугаар хороо, 30-31, 43-р хороо |
| 3 | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | 83 | Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо болон Бусад дүүргийн амьсгалын замын хүнд өвчлөл |
| 4 | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | 35 | Баянзүрх дүүргийн 1-3 дугаар хороо |
| 5 | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг | 40 | Чингэлтэй дүүргийн 4-6 дугаар хороо, ХЗДХЯ болон Хууль зүйн яамны харьяа байгууллага, Төрийн тусгай албан хаагчдын хүүхдүүд |
| 6 | Цэргийн төв эмнэлэг | 50 | Баянзүрх дүүргийн 16-р хороо, Батлан хамгаалах болон Зэвсэгт хүчний албан хаагчдын хүүхдүүд |
| 7 | АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг | 16 | Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо |
| 8 | Төмөр замын Нэгдсэн эмнэлэг | 75 | Баянгол дүүргийн 3, 4, 20, 25, 27, 28, 29-р хороо |

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 9/135 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХАРЬЯА ЭМНЭЛГИЙН ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙГ ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ҮЕИЙН ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ

| № | Эрүүл мэндийн байгууллага | Хүүхдийн орны тоо | Шилжүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх дүүрэг хороо |
|----|--|-------------------|--|
| 1 | Баянгол Эрүүл мэндийн төв | 200 | Баянгол дүүргийн 1, 2, 5-19, 21-23, 25, 30-34 дүгээр хороо |
| 2 | Баянзүрх Нэгдсэн эмнэлэг | 260 | Баянзүрх дүүргийн 4-7, 17-18, 22-24, 27-33, 37, 38, 39, 40, 41-р хороо |
| 3 | Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв Дарь эх нэгдсэн эмнэлэг (2024-12 сарын 01-ээс) | 30 | Баянзүрх дүүргийн 21-р хороо |
| 4 | Багахангай Эрүүл мэндийн төв | 22 | Багахангай дүүргийн хороод |
| 5 | Багануур Эрүүл мэндийн төв | 84 | Багануур дүүргийн хороод |
| 6 | Налайх Эрүүл мэндийн төв | 115 | Налайх дүүргийн хороод |
| 7 | Сонгинохайрхан Нэгдсэн эмнэлэг | 260 | Сонгинохайрхан дүүргийн 1-11, 18-29, 32-42-р хороо |
| 8 | Сүхбаатар Нэгдсэн эмнэлэг | 145 | Сүхбаатар дүүргийн 1-11 дүгээр хороо |
| 9 | Сүхбаатар Эрүүл мэндийн төв Сэлбэ нэгдсэн эмнэлэг (2024-12 сарын 01-ээс) | 100 | Сүхбаатар дүүргийн 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20-р хороо |
| 10 | Хан Уул Нэгдсэн эмнэлэг | 160 | Хан Уул дүүргийн 1-8 дугаар хороо |
| 11 | Чингэлтэй Эрүүл мэндийн төв | 125 | Чингэлтэй дүүргийн 1-3, 8-24 дүгээр хороо |

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 4125 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ҮЕД НИЙСЛЭЛИЙН
ЗАРИМ ДҮҮРГИЙН НАСАНД ХҮРЭГЧДИЙН ХЭВТҮҮЛЭН ЭМЧЛЭХ ОРНЫ
ТҮР ЗОХИЦУУЛАЛТ

| № | Эрүүл мэндийн байгууллага | Шилжүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх дүүрэг хороо |
|---|---|--|
| 1 | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | Чингэлтэй дүүргийн насанд хүрэгчдийн мэдрэлийн амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ |
| 2 | Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв | Сонгинохайрхан дүүргийн бүх хороодын Мэдрэл, дотрын амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ |
| 3 | Улсын гуравдугаар төв эмнэлэг | Чингэлтэй дүүргийн 8, 12, 16-18, 21-р хороодын насанд хүрэгчдийн дотрын тусламж, үйлчилгээ |
| 4 | Хан Уул дүүргийн Эрүүл мэндийн төв | Хан Уул дүүргийн бүх хороодын Мэдрэл, дотрын амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ |